



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 8/57

Онги

Мал тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"г" дахь заалт, Монгол Улсын статистикийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 314 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 1/1234 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2018 оны жилийн эцсийн мал тооллогыг чанартай зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Онги баг 1 дүгээр хэсэг: Д.Ундрал (Багийн Засаг дарга)

Гишүүд: С.Ганбаатар (Багийн иргэдийн нийтийн хурлын дарга)

Г.Дэлгэрдалай (Төслийн ажилтан)

Онги баг 2 дугаар хэсэг: П.Эрдэнэбаатар (ИТХ-ын дарга)

Ө.Эрдэнэтөгс (Жолооч)

С.Цэцгээ (Их эмч)

Д.Алтанцэцэг (2 дугаар багийн иргэн)

Мааньт баг: Т.Гэрэл (Засаг даргын орлогч)

П.Энхсайхан (Багийн засаг дарга)

М.Эрхэмбаатар (Насан туршийн боловсролын багш)

Б.Норовдорж (Багийн их эмч)

Найз баг: Ш.Өлзийбүрэн (Багийн Засаг дарга)

Р.Сүрэндаваа (Хаан банкны эрхлэгч)

Л.Төмөрбат (Жолооч)

Б.Хандбямба (Багийн их эмч)

Төгрөг баг: 1 дүгээр хэсэг: Б.Арсланбаатар (Багийн Засаг дарга)

С.Энхмаа (Багийн их эмч)

Төгрөг баг: 2 дугаар хэсэг Ч.Түвшинбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

Д.Мөнхнаран (Цэцэрлэгийн багш)

2.Сумын хяналтын тооллогын комиссын даргаар С.Болоржаргал (Тамгын газрын дарга), гишүүд Р.Тунгалагтуяа (Санхүү албаны дарга), Д.Жамьян (Нярав) нарыг томилсугай.

3. Мал тооллогын ажлыг хэт шуурхайлан ам тоо авч, шөнө оройтон явахгүй байх, малыг нүд үзэн тоолох, тавиул малыг тооллогод бүрэн хамруулж ажиллахыг багийн Засаг дарга нар болон тооллогын комисст үүрэг болгосугай.

4. Мал тооллогын комисст шаардагдах унаа, шатах тослох материалын хэрэгцээг тооцож бэлэн байдлыг хангуулах нөөцийг бүрдүүлэх, хяналтын тооллогыг, тооллогод хамрагдсан өрхийн 10-аас доошгүй хувьд явуулахыг хяналтын комиссын дарга (С.Болоржаргал)-д, мал тооллогын маягтуудын үзүүлэлтүүдийг бүрэн үнэн зөв нэгтгэн дүн мэдээг хугацаанд нь аймгийн статистикийн хэлтэст хүргэхийг төрийн сангийн мэргэжилтэн (Ч.Түвшинбаяр) нарт даалгасугай.

5. Мал тооллогын комиссоор ажиллаж байгаа албан хаагч нар томилолтын явцад Засгийн газрын 258 дугаар тогтоолын 1.7 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллахыг комиссын бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ТҮВШИНБААТАР